

Дөрвөлжин үсгийн зэс гэрэгэ хийгээд “алдах” гэх үсгийн тухай

Ж.Чимэддорж*

1. Дөрвөлжин үсгийн зэс хийцэт гэрэгэ тэмдгийн тухай

Их Монгол хийгээд Юань улсын үеийн гэрэгэ тэмдэг одоо хүртэл нэлээд илэрснийг Бээжин их сургуулийн Дан Бао Хай профессор тусгай өгүүлэл нийтэлж дүгнэн өгүүлсэн мөртөө, эдгээр гэрэгэ тэмдгүүдийг өртөө улааны гэрэгэ тэмдэг, ноёд түшмэдийн гэрэгэ тэмдэг хийгээд мухрих гэрэгэ тэмдэг гэх гурван төрөлд хуваасан билээ. Тэр түүхэн сурвалжийн баримттайгаар урталжин хэлбэрийн гэрэгэг III дэсийн ноёд сайд барс тэргүүт алтан гэрэгэ зүүдэг, IV, V дэсийн ноёд сайд барсын тэргүүнгүй алтан гэрэгэ зүүдэг, VI, VII дэсийн ноёд түшмэд мөнгөн гэрэгэ зүүдэг. Монгол хүний хувьд зөвхөн түмний ноёд сая барс тэргүүтэй алтан гэрэгэ зүүдэг, мянгад буюу зуудын ноёд барсын тэргүүнгүй алтан буюу мөнгөн гэрэгэ зүүдэг гэж тодолсон байдаг.¹

Орост хадгалагдаж байгаа хоёр дөрвөлжин үсгийн мөнгөн гэрэгэ, Дундад улсын Өвөр монголын Археологийн институтэд хадгалагдаж байгаа дөрвөлжин үсгийн мөнгөн гэрэгэ хийгээд Өвөр монголын Их сургуулийн музейд хадгалагдаж бүхий дөрвөлжин үсгийн алтан гэрэгэ зэрэг дөрвөн гэрэгэ бүр барсын тэргүүнгүй тул цэргийн ноёд түшмэдэд өгсөн гэрэгүүд болох ёстой. Үүнээс гадна, эдгээр бүхэн нь Юань улсын Чжи Юаний 15-р он (1278 он)-оос сүүлээр тархааж буулгасан дөрвөлжин үсгийн гэрэгэ тэмдгүүд болох юм.

2007 оны 9 сард би Дундад улсын Чүн Чин хотноо бүхий Баруун өмнөд их сургуульд эрдэм шинжилгээний айлчлалт хийх зуур тус сургуулийн түүхийн музейд дөрвөлжин үсэгтэй урталжин болон төгрөг хэлбэртэй зэс гэрэгэ тус бүр нэг хадгалж байгааг олж харав. Энэ хоёр гэрэгэ тэмдгийг тус сургуулийн профессор Дэн Цзы Цинь (1902-1984) дээр зууны 50-иад оны сүүлээр Сычуань мужийн Аба Төвд оронд газар шорооны өөрчлөлт хийж байх үес тэндэхийн Юань улсын үед байгуулагдсан Цоржийн сүмээс олсон гэж тус музейн хүмүүс надад хэлжээ. Тус гэрэгэг эрдэм шинжилгээнийхэнд мэдэгдээгүй өнөөдөр хүрчээ.

* Өвөр Монголын Их Сургууль, Монгол Судлалын Төв

¹ Дан Бао Хай, *Монгол эзэнт улсын гэрэгэ тэмдэг*, Европ ази судлалын сэтгүүл (хятад хэл)-ийн 4-р боть, Бээжин, Чжун Хуа Шү Цзюй хэвлэлийн хороо, 2004 он, 183-203-р нүүр, бас Dang Baohai. *The Paizi of the Mongol Empire*, Zentralasiatische Student, №.31, pp.33-62.

Урталжин хэлбэртэй гэрэгэ зэсээр үйлдэгдэж, урт 25 см, өргөн 8,2 см, дээр талын оосрын сүвийн хэсэг нь дотогшоо хумигдаж, манай мэдээжийн алт мөнгөн гэрэгийн гадар дүрсээс багахан зөрөөтэй. Гэрэгийн хоёр талд 5 мөр дөрвөлжин үсэг сийлэгдсэн нь харин тэдгээр алт мөнгөн гэрэгүүдтэй эгээ адил байна.

Зөв талын үсгийг галиглавал:

1. mong-ka (дунд мөр)
2. déng-rí yin kuᠰun-dur (зүүн мөр)
3. qa`an ne-re ku-tuk-tayí (баруун мөр)

Буруу талын үсгийг галиглавал:

4. bol-tu-kayí ken ü-lu (зүүн мөр)
5. bu-ši-re-gu al-da-ku u-ku-gu (баруун мөр)

Монгол үсэгт буулгавал:

*Мөнх тэнгэрийн хүчинд
Хаан нэр хутагтай болтугай. хэн үл
бүшрэх, алдах үхэх.*

Төгрөг хэлбэртэй зэс гэрэгийн гархи хүртэлх өндөр нь 18,4 см, диаметр нь 11,7 см, гархинаас доргош бариулын хэсэгт нь барсын тэргүүний дүрстэй. Гэрэгийн хоёр талд тус бүр 5 мөр дөрвөлжин үсэгтэй, нэг талд нь зөв тиг, нөгөө талд нь тонгоруу тигтэй.

Зөв талын үсгийг галиглавал:

1. mong-ka déng...rì
2. yin ku-ᠰun dur
3. qa`a-nu jar-lik ken
4. e-se bu-si-re`e su
5. al-da-tu kayí

Монгол үсэгт буулгавал:

*Мөнх тэнгэрийн хүчинд
хааны зарлиг хэн эс бүширвээс
алдтугай.*

Ийм янзын дөрвөлжин үсэгт төгрөг гэрэгэ одоо болтол 4 илэрч, энэхүү Баруун өмнөд их сургуулийнхтай нийлээд нийт 5 болоод байна.

Хамаг анхны нэг нь Орост 1881 онд илэрсэн, төмөр хийцтэй гэдэг.

Хоёрдугаар нь. Дундад улсын Ганьсу мужийн музейд буй, 1965 онд Ланьчжоу хотноо олдсон гэдэг.

Гуравдугаар нь. Америкт хадгалагдаж байдаг, дээрх дөрвөлжин үсэг нь мөнгөөр ширлэсэн гэдэг.

Дөрөвдүгээр нь. Төвдийн Дашлхүнбо хийдэд хадгалагдаж байгаа төмөр хийцэт алтан үсэгт дөрвөлжин үсгийн төгрөг гэрэгэ болно.

Эдгээр гэрэгэ дээрх дөрвөлжин үсгүүд нь бүр мөсөн адил, гэвч нөгөө нэг талын үсэг чухам юу болсныг бүр мэдээлсэнгүй нь харин сонин жигтэй учир болох юм.

Баруун өмнөд их сургуулийн энэхүү төгрөг гэрэгэ харин зэс тугалгын холимог хийцтэй байж, хөх боровтор өнгө илэрнэ. Гэрэгийн дунд орших 5 мөр дөрвөлжин үсгийн гадна цагираглан зассангүй онцлог нь бусад 4 гэрэгээс ондоо байна. Хоёр талын 5 мөр үсэг нь гүдгэр сийлэгдэж, нэг талын үсэг нь яг тонгоруу тигээр сийлэгдсэн нь маш сонин санагдана. Үсгийн хотгор хэсэгт улаан тамгын будаг хурагдаж шигдсэнийг үзвэл тус гэрэгэг бас нэг үе тамгын оронд хэрэглэж байсан бололтой. Үсгүүд нь алт мөнгөөр ширлэсэн эсэх нь мэдэгдэхгүй, бараг элэгдэж унасан ч байж мэднэ.

Тус сургуулийн урталжин, төгрөг хоёр гэрэгэ бүр Төвд орны сүмээс олдсон, Дашлхүнбо хийдэд бас нэг төгрөг гэрэгэ буй. Энэ нь Юаний үед Төвд оронд шашин төр хослуулан захирч байсныг харуулж буй. Эдгээр гэрэгэ дээрх дөрвөлжин үсгийн утга нь урталжин хэлбэртэй гэрэгэтэй бараг ойролцоо байгаагаас ажиглахад, бас л ноёд түшмэд зүүдэг гэрэгэ байх нь тодорхой. Дэн Цзы Цинь авгай төвдийн Аба (阿坝) орны Цорж сүмээс энэ 2 гэрэгэг олсон явдал нь Юаний төрөөс энэ сүмийн лам нарт өгсөн гэсэн түүхэн үнэнийг гэрчилж байгаа юм. Хэрвээ мөнгөн гэрэгэ зуудын ноёдод өгдөг юм бол, зэс гэрэгэ түүнээс доор зэрэгтэй хүмүүст өгөх ёстой. Эсвэл зөвхөн Төвдийн сүм хийдэд зориулсан ч байж мэднэ. Юань улсын үед Төвд орон өөрийн тусгай эрх мэдэлтэй байсан. Төвд орныг хамаарч засдаг Сюань хааны номын багш мэддэг мөрдсөн хамаа бүхий ноёд түшмэдийг хааны номын багш шалган мэдүүлдэг байв. Иймээс зэс гэрэгэг Жэн Юаний Төвдийн сүм хийдэд тусгай буулгаж, хаан төрийн эрх сүрийг мандуулж байсан гэж хэлэлтэй. Зэс гэрэгийн тухай “Юань ши”-д ер тэмдэглэсэнгүй болохоор бид үүний тухай улам гүнзгий ойлголт гаргаж арай чадахгүй байна. Юу ч гэсэн эдгээр гэрэгэ тэмдгээс Юань улсаас Төвд оронд хэрхэн засаг захиргаа явуулж байсныг нэг хэмжээнээ олж мэдэж чадна.

2. Гэрэгэ дээрх “алдах”, “алдтугай” хоёр үгийн ойлголт

Урталжин гэрэгэ дээрх дөрвөлжин үсгээр бичиглэсэн монгол үсгийн тухай эрдэмтэд олон арвин таньж тайлбарлаж судласан тул энд нуршихаа байя.² Зөвхөн “алдах”, “алдтугай” гэх үгсэд өөрийн үзэлтээ дурдсугай.

“алдах”, одоо ирээдүй цагийг илтгэх тэмдэг үйл үгийн хэлбэр. Үгийн үндэс “алд-”, энэ нь “алдаж гээх, алдал болох” гэсэн үндсэн утгаас гадна, “хожигдох дийлэгдэх” гэсэн шилжмэл утгатай байдаг. Бас сахиж цээрлэх зүйлээс “зөрчих, эндэл гаргах” зэрэг утгыг илтгэдэг. “Монголын нууц товчоон”-д “үл алдаад” (§ 255) (хятад аар 不失了 гэж орчуулсан), “есөн алдал алдаас” (§ 211) (хятад аар 九次罰罰呵 гэж орчуулсан) гэх мэтийн тэмдэглэлд “алд-” гэсэн үгийн утга нь сахил журмаас зөрчих, эндэлтэй болох гэсэн утгыг харуулсан үйл үг болно.

² Бао Сянь, *Өвөр Монголд шинэ олдсон Юань улсын үеийн дөрвөлжин үсэгт монгол хэлний алтан гэрэгэ*, Өвөр Монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл (хятад хэлээр), 2000 оны IV хугацаа, 30-32-р нүүр; Зуунаст, *Монгол Юаний үеийн урталжин хэлбэрийн зарлигийн гэрэгэ дэх үсгүүдийг тайлах нь*, (хятад хэлээр) Үндэсний судлал, 2007 оны 4-р хугацаа, 65-69-р нүүр

“алдал” гэсэн нэр үг нь тов тодорхой ^[1] “яллах, торгох” гэсэн утгатай байна. Тус үгэнд “-ху” гэсэн залгавар залгахад “алд” гэсэн утгыг багтаасан одоо ба ирээдүй цагийг заасан тэмдэг үйл үг болж бүтнэ. Орчин одоо үеийн монгол хэлэнд тэмдэг үйл үг “-ху” зүүвэртэй бол ер нь хойноо холбоос буюу туслах үг авч төгс өгүүлэхүүн болдог. Жишээлбэл: “алдахгүй, алдах болтугай” гэх мэт. Үүнээс гадна бас тодотгол, тусагдахуун болдог. Жишээлбэл: “алдах ёсон, алдах учир, алдахыг, алдахаа”. Бас байц, өгүүлэгдэхүүн болж чаддаг: “алдахаар тогтов, алдах нь алдав” гэх мэт.

Гэрэгийн бичигт “алдах, үхэх” хоёр үг зэрэгцэн оршиж, хойноо холбоос буюу туслах үг авч төгс өгүүлэхүүн бүтээж чадсангүй тул Зуунаст багш орчмын үед бичсэн өгүүлэлдээ “-ху, -хү” тэмдэг үйлийн залгаврын дараа ямар ч туслах үйл үг залгасангүй нь монгол хэлний өгүүлбэр зүйтэй нийцэхгүй гэж үзэн, “алдах үхэх” гэдэг хоёр үгийн хойно “болтугай” гэсэн үг залгавал сая нэг бүрэн бүтэн захирах хүсэх хэлбэрийн өгүүлбэр бүтнэ гээд эдгээр гэрэгүүдэд “болтугай” гэсэн үг бичигдсэнгүйн шалтгаан нь даруй гэрэгэ дээрх үсгийн зай дутсанаас болжээ гэсэн сонин үзэлт дурдсан байна.³

“алдах үхэх” гээд өгүүлбэрээ төгсгөсөн гэрэгэд Оросын Эрмитаж музейд хадгалагдаж байгаа уйгуржин монгол үсэгтэй Абдул ханы мөнгөн гэрэгэ багтана.⁴ Үүнээс үзэхэд “болтугай” гэсэн үсэг бичих зайгүй болсондоо товчилсон явдал огт биш болох юм. Дундад зууны монгол хэлэнд байтугай орчин одоо үеийн монгол хэлэнд ч дээр дурдсан тэмдэг үйлийн шинж чанараас гадна “-ху/хү” залгавартай тэмдэг үйл бас одоо ирээдүйг заасан, лавтай болох үйл явдлыг илэрхийлэх жинхэнэ үйл үг болж, өгүүлэхүүний үүргийг гүйцэтгэдэг зуршил зөндөө буй.

“Монгол Ойрдын цааз”-д:

*Монгол Ойрдод дайсан ирвээс хэл
өг. Тэр хэл сонсч байж захын
их ноёд эс ирвээс зуун хуяг зуун тэмээ мянган адуу авах.*

*Дөчиний дэмчийн хүүхний малын тоо
таван тэмээ, хорин таван бод дөчин
хонь авах.*

гэх мэт.⁵

Одоо үеийн монгол хэлний зүйр цэцэн үгэнд ийм тохиолдол арвин гардаг:

*Цааз мэдэхгүй хүн идэж үхэх
Цаг мэдэхгүй хүн хоцорч алдах*

³ Дээр дурдсан Зуунастын өгүүлэлд.

⁴ D. Tumurtogoo, G. Cecegdari, *Mongolian monuments in Uighur-Mongolian script* (XII-XVI Centurica), Introduction, Transcription and Bibliography, Institute of Linguistics, Academic sinica. Taipei, Taiwan, 2006, Plates IV, Paizi and Seal and Letters, Abd. pp. 721.

⁵ Дорнотив харьцуулан тайлбарласан “Ойрд цааз”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1985 он.

Үйл хурвал бороо орох
Монгол цугларвал цэрэг болох.

гэх мэт.

Ордосын нутгийн аялгуунд “-ху/-хү” залгавартай үйл үгийг өгүүлэхүүн болгож шууд ярьдаг:

За танайд эчиж цай уух аа.
Одоо би явах аа.
Тэр удахгүй ирэх ээ.

гэх мэт.

Их Монгол Юань улсын үест “-ху/-хү” залгавартай тэмдэг үйл үгийг жинхэнэ өгүүлэхүүн болгож, өгүүлбэрийн эцэст орж хэрэглэж байсныг эдгээр гэрэгийн бичгүүдээс мэдэж болно. Гэрэгийн бичиг хааны зарлиг болох тул хууль цаазын чанартай байж, өгүүлбэрийн гишүүн дутуу учир гарах ёсгүй нь мэдээж. Яг иймээс гэрэгэ бичигт “-ху/-хү” залгавартай тэмдэг үйл үгээр өгүүлбэрийн төгсгөл болгох нь ойлгомжтой учир болох юм.

“Алдах” гэсэн үг хятад хэлэнд монгол дуудлагаар 按答奚 гэж орчуулагдан, Монгол Юаний үеийн эрүүгийн тусгай нэр үүссэн байна гэж эрдэм шинжилгээнийхэн үздэг байна.

Зуунаст багшийн үзэхээр “алдах” гэсэн тэмдэг үйл үгийг Сүн улсын элчин Пэн Да Жа “Монгол Татарын бүрэн тэмдэглэл” гэсэн жуулчлалын тэмдэглэлд 按答奚 гэж хятад хэлэнд анх түрүү буруу галигласан. 奚 hei үсгээр “-ху” залгаврыг галиглахын оронд 忽 -hu үсгээр тэмдэглэх нь зүйтэй байсан гэж үздэг.⁶

Бан Лин Гүй авгай “алдах”-ын хятад дуудлага нь 按答奚 байх ёстой, гэвч “-ху” залгаврын дуудлага нь 奚 hei үсгийн дуудлагатай тэнцэхгүй, зөвхөн ойролцоо дуудлага болно гэж үздэг.⁷

Июй Да Жюнь гуай харин 按答 хоёр үсэг яг “алда-” буюу алдлын зөв дуудлага байж, 奚 үсэг нь харин хятад хэлний 死 (үхэх) гэсэн үгний аялгуу, “алдах” гэсэн үг даруй алах үхэх гэсэн утгатай гэж үздэг.⁸

Цзай Мэй Бяо авгай эртний хятад хэлний дуудлагатай 按答奚 бол “алдах”-ын эртний монгол дуудлагын оновчтой орчуулга, Поппегийн “алдах” гэсэн үгийг ирээдүй цагийг заасан нэр үг гэж тайлбарласан нь бүрэн зөв гэж үздэг.⁹ Үүнээс гадна Цзай Мэй Бяогийн илрүүлснээр бол Пэн Да Я Өгөөдэй хааны VI, VII-р он (1234-1235 он)-д Монголд элчлэгдээд тэр үед нэгэнтээ

⁶ Зуунастын дээрх өгүүлэлд.

⁷ Ван Лин Гуй, Түн Ци Тяо Гэ хянан тайлбарлалт гэх номын 110-р зүүлт тайлбар “按答奚”, Чжүн хуа Шү Цзай хэвлэлийн хороо, 2004 он, 57-р нүүр

⁸ Юй Да Цзюнь, “按答奚” -и тухай очүүхэн нягтлал, Европ ази судлалын сэтгүүл (хятад хэл)-ийн 4-р боть, Бээжин, Чжүн Хуа Шү Цзюй хэвлэлийн хороо, 2004 он, 28-р нүүр,

⁹ Цзай Мэй Бяо Г. 19-ийн Еүгийн Монгол гэрэгэ дахин тайлбарлах нь, (хятад хэл), Чжүн Хуа Вэн Шы Лүнь Цүн (Journal of Chinese Literature and History), Шанхай хуучин номын хэвлэлийн хороо, 2008 оны 2-р хугацаа, 26-р нүүр.

зуршсан 按答奚 гэсэн монгол нэр томъёог жуулчлалын тэмдэглэлдээ тэмдэглэсэн төдий, түүний хувийн орчуулга биш. Учир нь Өгөөдэй хааны тэргүүн он (1229 он)-ы бичгүүдэд тус үг олонтоо илэрсэн тул тус үгийг Пэн Да Я буруу галиглан тэмдэглэв гэж буруушааж болохгүй гэж дурдав. Энэ нь түүхэн баримт бүхий зөв үзэлт болох нь илэрхий.

Кливз гуай харин ондоо үзэлт дурдсан байдаг. Тэр 1240 оны Төрэгэнэгийн зарлигийн бичгийг уншин тайлбарлахдаа, тус зарлигийн бичигт бүхий “алдаг шитү” гэсэн үг даруй хятад үсгийн 按答奚-ийн зөв дуудлага гэж үзсэн байна.¹⁰

Добу багш бас түүний энэхүү саналыг зөвшөөрдөг.¹¹

Орчимхон Япон улсын эрдэмтэн Мацүкава авгай өгүүлэл нийтэлж Төрэгэнэгийн зарлигийн бичиг дэх “алдаг шитү” гэсэн үгийг “алдан гитү” гэж уншин, “алданги” гэсэн нэр үг яг хятад аялгуу 按答奚-тай тохиролцоно гэж үзээд, цаашид 17-р зууны үйсэн бичгийн цаазад бүхий,

*Түймэр алдсан хүнийг хэн үзсэн
хүн нэгэн морь тавлаж св, төлсөн
-ийг алданги тавт юун бээр түлвээс
төлцөстэй буй. Хүн үхвээс анзтай болов.¹²*

гэсэн тэмдэглэлээс “алданги” гэсэн нэр томъёог олж, “алда-”-д “-нги” дагавар залгаж үйлт нэр үг бүтсэн гэж маш оновчтой шинжилсэн байна.¹³

Миний үзэхээр “алд-” гэх хоёр үеийг хятад хэлний 按 үсгээр “ал-”, 答-аар “-да”-г тэмдэглэх нь бүрэн зөв болох нь мадаггүй. Гэвч 奚 үсгээр -нги дагаврыг тэмдэглэх нь харин зохисгүй болно. Дөрвөлжин үсгийн толь бичигт 奚 үсгийг hei гэж тэмдэглэж байдаг. “hei” дуудлага монгол аялгуу “-ги”-тэй тэнцэхээс биш “-нги” аялгуунаас маш зайдуу. Үүнээс бус нэг боломж гэвэл, тэр үед “алданги” гэсэн нэр үг дөхөмжөөд “алдаги” болоод хятад хэлэнд иймэрхүү тэмдэглэгдсэн ч юу магад.

Тус гэрэгэд “алдах үхэх” гэж зэрэгцээ бичсэн нь “алдалтай болох, үхэх болох” гэсэн утгыг харуулсан нь маш илэрхий. Поппегийн ойлголтоор “shall be guilty and die” (алдалтай болох бөгөөд үхэх) гэсэн нь яг цав зөв ойлголт болно.¹⁴ Алдалтай болвоос торгож яллах ёстой, хүнд алдалтай болбоос эрүү тулгаж үхэх ялд унах боломж бас байлгүй, бага алдалтай бол тохирсон эрүү тулгаж эд хөрөнгийг нь булааж авах, цөлөх зэргээр яллах ч магадгүй юм. Алдалтай болбол эрх биш үхэх ялтай болсон биш болохоор энд “алдах үхэх” хоёр зэрэгцэн

¹⁰ Cleaves, Francis Woodman, *The Sino-Mongolian Inscription of 1240*, Harvard Journal of Asiatic studies, Vol. 23, 1960, 961, 62-72 -р тал.

¹¹ Добу, *Уйсүржсин монгол үсгийн дурсгалт бичгүүд*, 4-р зүүлт, бээжин, Үндэсний хэвлэлийн хороо, 1983 он, 12-р тал.

¹² Хөдөөгийн Пэрлээ, *Монгол ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг*, Улаанбаатар, 1974 он. Үүнийг Takashi Matsukawa, in *Regards to alday-s:tu on the sino-Mongolian Inscription of 1240. Баруун хязгаарын түүх хэлний судлалын чуулган* (Historical and philological Studies of China's Western Regions) -ы 1-р эвхмэл, Бээжин, Шинжлэх ухаан хэвлэлийн хороо, 2007 он, 297-301-р талд лавламу.

¹³ Дээр дурдсан Мацүкавагийн өгүүлэлд.

¹⁴ Дээр дурдсан Цай Мэй Бяогийн өгүүлээс ишлэв.

орсон байна. Энэ нь Манжийн хааны анх үед хэрэгжүүлж байсан “*tuhere weile*” (оногдох ял) гэсэнтэй яг зохицох хууль цаазын байгуулалт билээ.

Төгрөг гэрэгэд “*алдтугай*” гэсэн захирах хүсэх хэлбэрээр “*алдал болтугай*” гэсэн шууд утга гаргах ёсгүй. “*Хааны зарлиг хэн эс бүширвээс алдтугай*” гэсэн үгийн логик утгаас ажиглахад, хааны зарлигаас эс бүшрэгсдийг алдалтай болгон залхаан яллах гэсэн утгатай байх нь тодорхой. Гэвч “*алдах*”, “*алдтугай*” гэсэн үгс тэр үес хууль цаазын эрүү ялын тусгай үг болж дассан тул, алдалтай болох, алдалтай болгон шийтгэж залхаатугай гэсэн утгаар ойлговол зохино.



Урталжсин гэрэгэ 1 (Зөв тал)



Урталжсин гэрэгэ 2 (буруу тал)



Төгрөг гэрэгэ 1 (Зөв тал)



Төгрөг гэрэгэ 2 (буруу тал)